



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар №

Амардалай


Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон
шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтын журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Дэлгэр-Эмт багийн нутаг дэсгэрт байршилтай 74135.2га газарт салхин сэнсний цахилгаан станцын зориулалтаар газар эзэмшүүлж, ашиглуулах газрын төсөл сонгон шалгаруулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн дотор газрын биржийн цахим системээр зохион байгуулсугай.

2. Төсөл сонгон шалгаруулалт хүлээн авах материалд тавигдах шаардлага, үндсэн шалгуурыг хавсралт ёсоор баталсугай.

3. Төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг цахимаар хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Золжаргал), Газрын даамал (Л.Мөнхсарнай) нарт үүрэг болгосугай.



4880200505

Сумын Засаг даргын мэдээний дүгээр
сарын 16-ны өдрийн 2022 дугаар захирамжийн
хавсралт

**ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ТӨСӨЛ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
ҮНДСЭН ШАЛГУУР**

Ерөнхий мэдээлэл:

Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 04 дугаар тогтоолоор батлагдсан “Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний 2528474 төлөвлөлтийн нэгж талбар.

Байршил: Дэлгэрцогт сумын Дэлгэр-Эмт баг

Зориулалт: Салхин сэнсний цахилгаан станц

Хэмжээ: 741352011 м2 /74135.2га/

Эрхийн төрөл: Эзэмших

Төсөл сонгон шалгаруулалтад оролцох үндсэн шалгуур:

Төсөл нь газар эзэмшүүлж, ашиглуулахад тавигдах шаардлага, ажил үйлчилгээний чиглэлд нийцсэн, “Төслийн удирдлага арга зүйн заавар” MNS ISO21500:2017 стандартын дагуу боловсруулсан байна.

Хэл: Монгол хэлээр (Гадаадын хуулийн этгээд бол эх хувь монгол хэлээр гадаад хэл дээрх хуувийг дагалдуулж болно)

Төсөл ирүүлэгчийн бүрдүүлэх материал:

- Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхний хуулбар
- Хамтарч ажиллах хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ
- Төслийн баримт бичиг
- Бүтээн байгуулалтын ажлын товч танилцуулга, шинээр бий болох ажлын байрны тоо хэмжээ, улс орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ, байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх бол технологийн танилцуулга, бүтээн байгуулалтын ажлын үе шатны төлөвлөгөө
- Салхин сэнсний цахилгаан станц байгуулах ажлын техник эдийн засгийн үндэслэл
- Хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо

Төсөл хүлээн авахад тавигдах шаардлага:

Төслийг газрын цахим биржийн систем www.mle.mn-ээр зарлаж, зохион байгуулах бөгөөд төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ дээрх цахим системээр хугацаанд нь ирүүлсэн төслийн материалыг үнэлнэ.

Төсөл сонгон шалгаруулалтын дүнг нийтэд зарласан өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан ялагчтай гэрээ байгуулна.

Холбогдох мэдээллийг www.mle.mn цахим хуудас, тодруулга, лавлагааг ГХБХБГазрын мэргэжилтний 80038555, сумын Газрын даамлын 88060992 утсаар холбогдож авна уу.